

Аудит хийгдсэн байгууллага:

"БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ"

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
ДОТООД АУДИТЫН ХОРОО**

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН –

АУДИТ ХИЙСЭН
БАЙГУУЛЛАГА:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ДЭРГЭДЭХ
“ДОТООД АУДИТЫН ХОРОО”

АУДИТ ХИЙГДСЭН
БАЙГУУЛЛАГА:

“БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ”

АУДИТЫН ТӨРӨЛ:

ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА:

2024.03.26-2024.04.30

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Ган-Очир

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга

Гишүүн:

А.Гэрэлт-Од

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын, ахлах шинжээч

Д.Мөнгөнсүвд

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын, ахлах шинжээч

Ц.Ууганбаяр

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын шинжээч

Нарийн бичгийн дарга:

Б.Цолмон-Эрдэнэ

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын шинжээч

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
 - 2.1 Аудитын зорилго
 - 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт
 - 2.3 Аудитын арга, аргачлал
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТҮРШЛАГА
 - 3.1 Засаглалын талаар
 - 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
 - 3.3 Дотоод хяналтын системийн талаар
4. АУДИТЫН ҮР ДҮН
5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм, 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Барилга, хот байгуулалтын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хороо”-ны 2024 оны төлөвлөгөөний дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны жилийн эцсийн байдлаарх санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг танилцуулж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Барилга, хот байгуулалтын яамны санхүү, төсвийн гүйцэтгэл, урсгал зардалд дотоод аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны санхүүгийн тайланд санхүүгийн дотоод аудитыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Санхүүгийн баримт бичиг, бүртгэл хөтлөлт, зориулалт, зарцуулалт, гүйцэтгэл
- Аудит, хяналт шалгалтын тайлан, зөвлөмжийн хэрэгжилт
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

2.3 Аудитын арга, аргачлал

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газрын дарга нарт дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бүтэц орон тоо зэргээс олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээ /ОУМПХ/
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн Газар, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталж гаргасан холбогдох эрх зүйн баримт бичгүүд

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Барилга, хот байгуулалтын яам нь Төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлж, Төрийн захиргааны төв байгууллагуудыг манлайлан түүчээлж, Олон улсын чанарын менежментийн тогтолцоо “ISO 9001:2015” стандартыг нэвтрүүлсэн анхны яам болж, Олон улсын баталгаажуулалтын гэрчилгээг 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр гардан авсан сайн туршлагатай байна.

3.1. Засаглалын талаар

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 488 дугаар тогтоолоор баталж, үйл ажиллагааны чиглэл, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлсон байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025

онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Шинэ сэргэлтийн бодлого” гэх мэт томоохон хөтөлбөрт тусгагдсан сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, бодлого, төлөвлөлт, удирдлага, зохицуулалтаар хангахад чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Барилга, хот байгуулалтын яам нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулсан боловч албажуулаагүй, тусдаа нэгж байгуулаагүй байна. Газар, хэлтэс тус бүрээр эрсдэлийг тодорхойлж гаргасан. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/164 дүгээр тушаалаар “Бүртгэлийн хяналтын журам”-ыг баталсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/167 дугаар тушаалаар “Удирдлагын дүн шинжилгээ хийх журам”-ыг баталсан. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/157 дугаар тушаалаар “Чанарын менежментийн тогтолцоонд дотоод аудит хийх журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

3.3. Дотоод хяналтын системийн талаар

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 154 дүгээр тушаалаар “Барилга, хот байгуулалтын яамны дотоод аудитын хорооны ажиллах журам”-ыг батлан мөрдөн ажилладаг. Барилга, хот байгуулалтын яам нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хороо” байгуулан ажилладаг.

4. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудлын төрөл	Дотоод аудит
Илэрсэн Асуудал 1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Бараа материал худалдан авсан гүйлгээний төлбөрийн баримтын бүрдэл дутуу. Анхан шатны баримт болох хамтран ажиллах гэрээний бүрдэл дутуу.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Анхан шатны баримтыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэх, ибаримтын системд баталгаажсан баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнах. Хамтран ажиллах гэрээний бүрдлийг хангасан байх.	
Асуудлын үндсэн шалтгаан: Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.	
Зөвлөмж: 1. НББ-ийн тухай хуулийн 5.1.4 Нягтлан бодох бүртгэлийн “үнэн зөв байх” зарчим, 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” заалтуудыг хэрэгжүүлж ажиллах; 2. Захиргааны ерөнхий хууль болон Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх гэрээний хууль эрх зүйн зохицуулалтыг баримталж ажиллах.	

Илэрсэн асуудлын төрөл	Дотоод аудит
Илэрсэн Асуудал 2	Нийгмийн даатгалын тайлангийн тайлагналт ,Татварын хэлтэст нийт 81,634,053.59 төгрөгийн авлага үүсгэсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал:

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст 81,221,856.29 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг шилжүүлсэн байна. Уг гүйлгээ ХХОАТ-ын данс андуурсан гүйлгээгээр 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр буцаагдсан ч 2023 оны 08 дугаар сарын 31-ны өдөр дахин 81,221,856.29 төгрөгийн ХХОАТ болон 103,000,000.00 төгрөгийн ХХОАТ-ыг Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлсэн байна. Тооцооллоос давсан ХХОАТ-ыг шилжүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст нийт 81,634,053.59 төгрөгийн авлага үүсгэсэн байна. Нийгмийн даатгалын тайлангийн цахим системд 2023 оны 08 дугаар сарын тайланг илгээхдээ 07 дугаар сарын тайлан буюу 311,457,320.08 төгрөгийн тайлан илгээсэн алдаа гарсан байна. 2023 оны 08 дугаар сарын тайлан 184,789,022.46 байсан байна. Энэхүү алдааг залруулахаар Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 3/114 албан тоотыг Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21, 25, 26 дугаар зүйлийг тус тус үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

Асуудлын үндсэн шалтгаан:

Тооцооллоос давсан үнийн дүн бүхий ХХОАТ төлсөн. Нийгмийн даатгалын тайлангийн тайлагналт алдаатай.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Төсвийг зохистой удирдаагүй, Нийгмийн даатгалын тайланг үнэн зөв гаргаагүй.

Зөвлөмж:

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл "Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх" төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах;
2. Яамны 2023 оны 08 дугаар сарын нийгмийн даатгалын тайланг залруулж тайлагнах.

Илэрсэн асуудлын төрөл	Дотоод аудит
Илэрсэн Асуудал 3	Төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал хангалтгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал:

Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогын комиссыг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/32 дугаар тушаалаар томилж, 2023.06.25-30-ны өдрийн хугацаанд тооллогыг хийж гүйцэтгэсэн байна. Эхний хагас жилийн дотоодын тооллогын илтгэх хуудсанд 10,914,955 төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тоологдсон байна. Комисс үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Харин 2023 оны жилийн эцсийн тооллогын комиссыг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/67 дугаар тушаалаар томилж 2023.12.10-15 өдрийн дотор тооллогыг хийж гүйцэтгэсэн байна. Эд хөрөнгийн тооллого явуулсан тухай илтгэх хуудсанд нийт 1,626,159,086.25 төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдож 1,225,446,595.21 төгрөгийн элэгдэл 392,385,491.04 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, 14,207,655 төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тоологдсон байна. Тооллогоор яамны албан хаагчдын эд хөрөнгийн картад бүртгэлтэй цаашид албан хэрэгцээнд ашиглах боломжгүй эвдрэл гэмтэлтэй 23 нэр төрлийн 62 ширхэг хөрөнгийг

<p>актлуулах санал гаргасан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 842 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Эд хөрөнгийн тооллогын бүртгэл, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл, коджилт дутуу, коджилт ЗТБХБЯ байх үед хийгдсэн шинэчлэх шаардлагатай байна.</p>
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтын бүртгэл хийгдсэн байх.</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Эд хөрөнгийн тооллын бүртгэлд байгууллагын нэр, эд хөрөнгийн нэр төрөл, хаана ашиглагдаж байгаа, хөрөнгийн чанар байдал зэргийг тэмдэглэхийн хамт тооллогын бүртгэлийн хуудас бүрийн ард тооллогын комиссын дарга, гишүүд, эд хариуцагч гарын үсэг зурсан байх.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалтын бүртгэл, тайлагналт, хяналт дутуугаас хөрөнгө шамшигдах үнэгүүдэх үр дагавартай.</p>
<p>Зөвлөмж:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70,71,72 дахь заалтын дагуу байгууллагын дотоод тооллогыг цаг хугацаанд нь үр дүнтэй, нүд үзэн зохион байгуулж, хөрөнгийн тоо хэмжээг тулган баталгаажуулах ажлын зохион байгуулж хэвших; 2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 842 дугаар "Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай" тогтоолын биелэлтийг хангаж ажиллах.

Илэрсэн асуудлын төрөл	Дотоод аудит
Илэрсэн Асуудал 4	Жолоочийн тооцооны хуудасны бүртгэл дутуу байна.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
<p>Бодит байдал: Сар бүр 442,767 төгрөгийн шатахууны зардал гарсан байна. 1, 2, 8, 9, 11,12 дугаар саруудын шатахууны зарлын гүйцэтгэлийг гаргахдаа жолооч хэдэн км явснаа хянаад гарын үсэг зураагүй.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Сангийн сайдын 2017 он 347 дугаар "Маягт, заавар батлах тухай" тушаалаар жолоочийн тооцооны хуудсыг хөтлөх.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Шатахууны зардлын гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг бүртгэлийг дутуу хөтөлсөн байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргах</p>	
<p>Зөвлөмж:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тээвэр шатахууны зардалд зарцуулсан орлого, зарлагын тооцоог сар бүр хийж үлдэгдлийг тулган баталгаажуулах. 	

Илэрсэн асуудлын төрөл	Дотоод аудит
Илэрсэн Асуудал 5	Цалин хөлстэй холбоотой асуудал
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал:

Албан хаагчдын цалинг олгохдоо төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн цагийн бүртгэлийн дагуу цалин бодогдоогүй байна. Өвчтэй, чөлөөтэй, томилолтоор явсан, ажил тасалсан албан хаагчдад хоол унааны хөнгөлөлтийг олгосон байна. Албан хаагчдын алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдлийг тушаалын дагуу олгож эхлэх өдрөөс өгөөгүй, зарим саруудад олгогдоогүйн улмаас нэмэгдэл цалингийн зөрүү үүсгэсэн байна. Цалингийн зөрүү үүссэн тухай нотлох баримт, тэмдэглэл байхгүй байна. Тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь гаргаагүйн улмаас нөхөж өгөхөд цалингийн зөрүү үүссэн байна. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/101, Б/236, Б/240 дүгээр “Албан хаагчдад урамшуулал олгох тухай” тушаалаар яамны албан хаагчдын 2023 оны хагас, бүтэн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшууллыг олгохдоо гарсан тушаал шийдвэрийн урамшууллын үнийн дүнгээр олгоогүй, зөрүүтэй олгогдсон байна. Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/102 дугаар тушаалаар урамшуулал олгож урамшууллыг давхардуулж хавтгайруулсан байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн 102.1.5 дахь заалт болон холбогдох журмын дагуу нягтлан бодох бүртгэлийг бүртгэх

Асуудлын үндсэн шалтгаан:

Цалин хөлсийг цаг тухайд холбогдох тушаал шийдвэр бусад нотлох баримтын дагуу үнэн зөв олгосон байх.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв гаргах

Зөвлөмж:

1. Албан хаагчдын цалинг олгохдоо төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн цагийн бүртгэлийн дагуу олгох;
2. Цалин хөлсийг цаг тухайд холбогдох тушаал шийдвэр бусад нотлох баримтын дагуу үнэн зөв алдаагүй олгож хэвших;
3. Албан хаагчдын алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл болон бусад нэмэгдлийг нягтлан тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь олгох,шатахууны зардалд зарцуулсан орлого, зарлагын тооцоог сар бүр хийж үлдэгдлийг тулган баталгаажуулах.

Илэрсэн асуудлын төрөл	Дотоод аудит
Илэрсэн Асуудал 6	Шилэн дансны мэдээлэл хөтлөлт
Асуудлын ангилал	Нөлөө багатай

Бодит байдал:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан, төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн биелэлт, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр), Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Төсвийн байгууллагын хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан,

дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн мэдээллийг хугацаанд нь оруулаагүй, хугацаа хоцорч мэдээлсэн байна. Шилэн дансны цахим мэдээлэлд байршуулбал зохих 8-р сард 5,600,000.00 төгрөг, 9-р сард 14,107,00.00 төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Шилэн дансны тухай хууль нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилготой.

Асуудлын үндсэн шалтгаан:

Байршуулж буй мэдээллүүдийг иж бүрэн, ойлгомжтой байдлаар оруулаагүй. Шилэн дансанд байршуулж буй мэдээллүүд нь олон нийтэд нээлттэй, ил тод байх.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хуулийн дагуу мэдээллийг иж бүрэн байршуулаагүйгээс болж эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцогдох, бусад хөндлөнгийн хяналт шалгалтад хамрагдах, олон нийт нийгэмд үзүүлэх сөрөг хандлага зэрэг олон сөрөг нөлөөтэй.

Зөвлөмж:

1. Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн байршуулах.

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
“Сайжруулах шаардлагатай”	Засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХШУДАГ-ын дарга бөгөөд
Дотоод аудитын хорооны гишүүн



Х.Ган-Очир

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

Дотоод аудитын хорооны
нарийн бичгийн дарга



Б.Цолмон-Эрдэнэ